

Батлав:

Л. Баян-Алтай

Хүүхдийг Ивээх Сан

Монгол дахь Суурин төлөөлөгч



“Олуулаа ойн төгөл бүтээцгээ” уур амьсгалын кампанит ажил ба Нээлттэй микрофон (Open mic) арга хэмжээний удирдамж

Төслийн нэр: “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төсөл

Төслийн хугацаа: 2024-2027

Төслийн зорилтот газар: Налайх дүүргийн төв талбай

Үндэслэл

Хүүхдийг Ивээх Сан нь нийслэлийн Налайх дүүрэгт “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийг 2024-2027 онд хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Налайх дүүрэгт дүүргийн 3,000 орчим хүүхэд, залуус, иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлж, тэдний оролцоотойгоор мод тарьж ойн төгөл байгуулах зорилготой.

Төслийн хүрээнд, олон нийтэд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг мэдээллийг түгээх сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд **“Олуулаа ойн төгөл бүтээцгээ”** уриан дор уур амьсгалын кампанит ажил “Open Mic” өдөрлөгийг 2026 оны намар буюу 9 дүгээр 24-ний өдөр Налайх дүүрэгт зохион байгуулна.

Энэхүү өдөрлөгөөр хүүхэд, залуус, иргэдэд уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчныг хамгаалах, мод тарих, ойн төгөл байгуулахын ач холбогдлын талаарх мэдээллийг сонирхолтой, оролцоонд суурилсан хэлбэрээр хүргэнэ. Түүнчлэн хүүхэд, залуус өөрсдийн мэдлэг, үзэл бодол, уриалга, дуу хоолойгоо олон нийтэд хүргэж, бусдыгаа байгаль орчны төлөө бодит үйлдэл хийхэд уриалах боломжтой юм.

Өдөрлөгийн зорилго

Налайх дүүргийн хүүхэд, залуус, иргэдийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүүхэд, залуусын дуу хоолой, оролцоог олон нийтэд хүргэж, байгальд ээлтэй зан үйл болон бодит үйлдлийг дэмжихэд өдөрлөгийн зорилго оршино.

Зорилт

- Хүүхэд, залуусын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, үзэл бодол, дуу хоолойг олон нийтэд хүргэх.
- Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, мод тарих, ойн төгөл байгуулахын ач холбогдлын талаарх мэдээллийг оролцоонд суурилсан, сонирхолтой хэлбэрээр түгээх.
- Иргэд, олон нийтийн мод тарих, байгаль орчноо хамгаалах сонирхол, сэдлийг нэмэгдүүлэх
- Оролцогчдыг уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодит үйлдэл хийх амлалт, уриалгад нэгдэхэд уриалах
- Хүүхэд залуусын үе тэнгийнхэндээ эерэг нөлөө үзүүлэх, манлайлах оролцоог дэмжих.

Хүлээгдэж буй үр дүн

- 300-аас доошгүй хүүхэд залуус, иргэд өдөрлөгт оролцож, уур амьсгалын өөрчлөлт, байгаль хамгааллын талаарх мэдээлэл авсан байна.
- Хүүхэд, залуус өөрсдийн дуу хоолой, үзэл бодол, уриалгыг олон нийтэд хүргэсэн байна.
- Оролцогчид мод тарих, арчлах болон байгальд ээлтэй зан үйлийн талаар бодит үйлдэл хийх амлалт өгсөн байна.

Зохион байгуулагчид тавих шаардлага

- Мэргэжлийн дуугаралттай хөгжим аппаратуртай ажиллах: Гадаа задгай талбайд мэргэжлийн дуугаралттай хөгжим аппаратаа суурилуулах.
- Promo видео зарлал гаргах: Арга хэмжээний promo видео зарлал бэлтгэх, гаргах. Үйл ажиллагаа зохион байгуулах талбай буюу Налайх дүүргийн төв талбайг үйл ажиллагаа зохион байгуулахаас өмнө очиж танилцах шаардлагатай.
- Highlight videos болон өндөр чанартай дүрс бичлэг: Арга хэмжээний highlight video болон үйл ажиллагааны өндөр чанартай дүрс бичлэг авч, монтажлан, захиалагчид хүлээлгэж өгөх.
- 2-3 цагийн арга хэмжээг зохион байгуулах: Арга хэмжээг 2 цагийн турш үргэлжлүүлэхэд шаардлагатай техник мэргэжлийн болон хөтлөлт, идэвхжүүлэлтийн мэргэжлийн багтай байх.
- Налайх дүүрэгт үйл ажиллагааг зохион байгуулах.
- Гадаа задгай талбайд олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулж байсан туршлагатай, өөрсдийн албан ёсны сошиал медиа платформуудтай, зохих хэмжээний дагагчидтай байх буюу үйл ажиллагааны чиглэлээрээ нийтэд танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн байх.
- Оролцогчдыг эх дэлхийнхээ төлөө өөрсдийн богино уриалга, амлалт, үзэл бодлоо илэрхийлэхэд оролцуулах;
- Хүүхэд, залуусын дуу хоолойг онцолсон интерактив тоглоом, quiz, challenge, performance зэрэг идэвхжүүлэлтийн хэсэгтэй байх;

Бүрдүүлэх материал

Сонирхсон өргөдөл гаргагчид дараах материалыг ирүүлнэ үү:

1. Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө, хэрэгжүүлэх аргачлал
2. Багийн танилцуулга болон техник, мэргэжлийн тоног төхөөрөмжийн жагсаалт, мэдээлэл
3. Адил төстэй үйл ажиллагаа зохион байгуулсан 3 -аас доошгүй ажлын танилцуулга болон холбогдох линк
4. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай бүх зардлыг тусгасан дэлгэрэнгүй үнийн санал

Төсөв

№	Зардлын нэр	Дүн
1	Open Mic зохион байгуулах	8,000,000
2	Бусад (Эко клубүүдийн бүүтүүдэд)	3,000,000
Нийт		11,000,000

Техникийн болон үнийн санал хүлээн авах

Техникийн болон үнийн саналыг **2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 17.00 цагаас өмнө** mongolia.procurement@savethechildren.org хаягаар хүлээн авна.